

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

БАТЛАВ  
 БУЛГАН АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН  
 ДАРГА Д.ДЖАГВАСҮРЭН

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2024 оны 01 сарын 29 өдөр

Д.Д	ҮЗҮҮЛЭЛТИЙН НЭР	ҮР ДҮН
1	Байрлал	Булган аймаг, Булган сум, Ханжаргалант баг, Магсаржавын гудамж, Татварын хэлтсийн байр
2	Объектийн талбай	1292 м <sup>2</sup> газартай, барилга байгууламжийн хувьд 864 м <sup>2</sup> албан конторын байр, 216 м <sup>2</sup> авто машины граж, 1292 м <sup>2</sup> төмөр хашаа, 56 м <sup>2</sup> бетонон хучилттай автомашины зогсоолтой
3	Тус объектонд ажиллах хүч, цагийн хуваарь	Тус байр /объект/ нь 24 цагийн турш байнгын харуул хамгаалалтад байна. Объектод тогтмол 1 харуул ажиллуулах бөгөөд алба хаагчийн ердийн ажлын өдрийн үргэлжлэл өглөө 09:00 цагт ажил хүлээлцсэнээр эхэлж дараа өдрийн өглөө 09:00 цагт ажил хүлээлцсэнээр дуусна. Хэлтсийн гадаах хаалгыг нээх, хааж түгжих ажлыг байнгын харуулууд тогтмол хийж гүйцэтгэнэ. Амралтын өдрүүдэд объектийг нээх, хаах ажлыг байнгын харуул гүйцэтгэж тогтмол хяналтыг тавьж аюулгүй байдлыг ханган ажиллана. Амралтын өдрөөр ажиллах ажлын цаг өглөө 09:00 цагт ажил хүлээлцсэнээр эхлэж дараа өдрийн өглөө 09:00 цагт ажил хүлээлцсэнээр дуусна. Харуул хамгаалалтын ажилтан нь 24, 72 гэсэн хувиарын дагуу ажиллах боломжтой байна.
4	Шуурхай алба /эргүүл/	Болзошгүй гэмт аюул, хулгай, дээрмийн үед бэлэн ажиллах хүний нөөцтэй байх.
5	Аюулгүй байдлын дохиолол	Байгууллагын объектод 24 цагийн турш харуул, хамгаалалтын ажилтан ажиллах тул хөдөлгөөн мэдрэгч, дохиоллын систем байршуулах шаардлагагүй
6	Оффис, төвтэй байх	Өөрийн хяналтын байртайг нотолсон гэрчилгээ эсвэл түрээсээр ажилладаг бол түрээсийн гэрээний хуулбар

7	Үйлчлүүлэгчийн эд хөрөнгө, бараа материал	Татварын хэлтсийн байр болон /нийт объект/ оффис доторх албан хэрэгцээний компьютер, тоног төхөөрөмж, автомашинууд, ширээ сандал бусад албаны өмчлөлийн эд зүйлс, архивын өрөө, авто машины граж, хэлтсийн 00 давхар буюу склад/агуулах/-ын бүрэн бүтэн байдлыг хамгаалах, хадгалах, хэлтсийн эзэмшлийн хашаан доторх зүлэг, мод бут сөөг, цахилгааны шон, трансформатерын бүрэн бүтэн байдлыг хамгаалах үүргийг хүлээж ажиллана.
8	Үйл ажиллагааны талаар	Объектийн талаархи мэдээллийг холбогдох албан тушаалтануудад тайлагнах, тухайн ээлжинд гарсан хамгаалалтын ажилтнууд илтгэх хуудас бичих, ээлж хүлээлцсэн тухай тэмдэглэл хөтлөх
9	Объектийн дотор дэг журам	Гадны хүн оруулахгүй, уулзах хүнээс нь ажилтнаас нь зөвшөөрөл авч оруулж байх. Дэг журам алдагдсан үйлдэл гарч бусдын амь нас, бие, эрүүл мэнд, эд зүйлд хохирол учирч болох нөхцөл үүссэн, байгууллагын хэвийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхүйц гаднаас гэмт хэргийн шинжтэй хандлага үйлдсэн, хулгай, дээрэм, танхай хэрэг зөрчил гарсан нь өөрөө зогсоох боломжгүй үед тусгай хэрэгслийг хэрэглэх, таслан зогсоох, тухайн тохиолдолд үйлчлүүлэгч байгууллагын удирдлагад нэн даруй мэдэгдэж байх. Хууль хяналт болон цагдаагийн байгууллагатай нягт хамран ажиллах, гэмт хэрэг, зөрчлийг мэдээлэх
10	Нэмэлт ажил	1. Шаардлагатай үед байгууллагын дотоод үйл ажиллагаанд оролцох /тавилга эд хогшил зөөх, ачиж буулгах, лац ломбо шалгах/, олон нийтийг хамарсан ажлуудад оролцох 2. Гадна дотны цэвэрлэгээ тохижилтыг хариуцах /үүдний цас, хог цэвэрлэгээ, засаж сайжруулах/ автомашины зогсоолын бүрэн бүтэн байдал, цэвэрлэгээг хариуцах

АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙРШИЛ, ҮНЭ, ХУГАЦАА

№	Объектын байршил	Нийт төсөвт өртөг	Объектын зориулалт	Хамгаалалтын үйлчилгээ авах хугацаа
1	Булган аймаг, Булган сум, Ханжаргалант баг татварын газрын өөрийн байр	39,600,000	Төрийн захиргааны байгууллага	2024.02.08- өдрөөс Дараагийн үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулан гэрээ байгуулах хүртэл